



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 405

Арвайхээр

**Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэрэгтэй
холбоотой үйл ажиллагааг зохицуулах ажлын хэсэг
томилох тухай**

Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Эрүүл Мэндийн Сайдын “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох тухай” 2019 оны А/513 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг ахиулах, олгохтой холбоотой хүсэлтийг хүлээн авч, асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, тодорхойлолтыг мэргэшлийн нийгэмлэг, холбоонд хүргэх ажлыг зохион байгуулах ажлыг хэсгийг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг ханган, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг ахиулах, олгохтой холбоотой асуудлыг чанартай зохион байгуулж, идэвхтэй ажиллахыг ажлын хэсгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилт болон Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэрэгтэй холбоотой үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдлын албаны дарга (Д.Болормаа), Хүний нөөц, сургалт хөгжлийн албаны дарга (Л.Алтантөгс) нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Э.ХҮДЭРЧУЛУУН

Захирлын 2021 оны 01 дугаар сарын 22-ны
өдрийн 14 дугаарын тушаалын хавсралт



Эмнэлгийн мэргэжилтний мэргэшлийн зэрэгтэй
холбоотой үйл ажиллагааг зохицуулах ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч: Д.Мөнхнасан /Эмчилгээ эрхэлсэн дэд захирал/

Нарийн бичиг: Л.Алтантөгс /Хүний нөөц, сургалт хөгжлийн албаны дарга/

Гишүүд: Д.Болормаа /Эмнэлгийн тусламж чанар аюулгүй байдлын албаны дарга/

Б.Одончимэг /Ёс зүйн хорооны нарийн бичиг/

Ц.Төмөрцоож /Сувилахуйн албаны дарга/

С.Нэргүйбор /Хуулийн зөвлөх/

Н.Төгс-Очир /Аймгийн эрүүл мэндийн газрын Хүний нөөцийн менежер/
/зөвшилцсөнөөр/

--0--